



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 09 өдөр

Дугаар 421

Улаанбаатар хот

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр”  
хязгаарлагдмал хариуцлагатай  
компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 59 дүгээр зүйлийн 59.2, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Засгийн газрын 2017 оны “Төрийн өмчит компани байгуулах тухай” 92 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Засгийн газрын 2018 оны “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 02, “Газрын тос боловсруулах үйлдвэр барих дэд бүтцийн бүтээн байгуулалтын талаар авах арга хэмжээний тухай” 21 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх, газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажилтай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 108 дугаар тогтоолоор баталсан “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийн 9.6, 10.1 дэх заалтыг дор дурдсанаар тус тус өөрчилсүгэй.

“9.6.Гүйцэтгэх захирал нь компанийн дэд захирлыг томилох, чөлөөлөх тухай асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай зөвшилцөнө. Шаардлагатай бол Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар өөрийн санаачилгаар тэдгээрийг албан тушаалаас нь чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж болно.”

“10.1.Компанийн гүйцэтгэх захирал, дэд захирал, менежер, ерөнхий нягтлан бодогч, албаны дарга нарыг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.”

2.“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн зохион байгуулалтын бүтцийн схемийг хавсралтад зааснаар шинэчлэн баталсугай.

3.“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн орон тооны дээд хязгаарыг 14 байхаар шинэчлэн тогтоосугай.

4.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулах тухай” 108 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

5.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА


Б.ГАВАА



0002261

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2018 оны 10 дугаар сарын 09 ны өдрийн  
421 дугаар тогтоолын хавсралт

**"МОНГОЛ ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР" ТӨРИЙН ӨМЧИТ  
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН  
ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН СХЕМ**  
(Үйлдвэрийг барьж байгуулах хүртэлх хугацаанд)



Орон тооны дээд хязгаар-14 хүн